

БАТЛАВ.  
АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ  
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГА




Ж.ЦОЛМОН

АГААРЫН ХӨЛГИЙН БОДИТ ХЯНАЛТЫН ТӨХӨӨРӨМЖҮҮД  
(FDR/CVR), НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН (АТС)  
БИЧЛЭГИЙГ АВАХ, ХАМГААЛАХ, ХАДГАЛАХ ЖУРАМ

Баримт бичгийн код	АХОЗШША - 25-10		
Баталсан огноо:	2025 он- 11 сар- 22 өдөр		
Хянасан:	Албан тушаал, нэр Х. Наранзүү	Огноо 2025. 11.21	Гарын үсэг
Боловсруулсан:	Албан тушаал, нэр У. Буянбадрах	Огноо 2025. 11.21	Гарын үсэг

### Өөрчлөлтийн бүртгэл

Өөрчлөлтийн дугаар	Өөрчлөлтийн товч тайлбар	Өөрчлөлт оруулах хэсэг	Өөрчлөлт хийсэн ажилтны нэр, албан тушаал	Огноо	Гарын үсэг
1	Шинэ хууль, дүрэм	Бүгд	Шинжлэн шалгагч	2025. 11.12	
2					
3					

### Түгээлтийн жагсаалт

№	Баримт бичиг	Хэнд (түгээх нэгж/байгууллага)
1	Журам	Шинжлэн шалгагч нарт
2		
3		

## Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмаар Чикагогийн конвенцын Хавсралт 13-ын (Attachment D), "Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хууль, Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны дүрэмд нийцүүлэн агаарын хөлгийн осол, зөрчлийн үед агаарын хөлгийн бодит хяналтын төхөөрөмжүүд /нислэгийн өгөгдөл, бүхээгийн яриа бичлэг/, нислэгийн хөдөлгөөний удирдлагын холбооны ярианы бичлэг, холбогдох бичиг баримтуудыг авах, шинжлэн шалгах ажиллагаанд ашиглах, хамгаалах, хадгалах зэрэг үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба (цаашид "Алба" гэх)-аас агаарын хөлгийн осол, зөрчлийн үед агаарын хөлгийн нислэгийн өгөгдөл, бүхээгийн яриа бичлэг, нислэгийн хөдөлгөөний удирдлагын холбооны ярианы бичлэг, холбогдох бичиг баримтуудыг авч ашиглахад ICAO-ийн Doc 9756, Doc 9962 бичиг баримтад заасан зааврыг мөрдлөг болгоно.

1.3. Монгол улсын нутаг дэвсгэрээс гадна Монгол улсад бүртгэлтэй, Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг эрх бүхий этгээдийн агаарын хөлөгт тохиолдсон осол, ноцтой зөрчлийн үед агаарын хөлгийн нислэгийн өгөгдөл, бүхээгийн яриа бичлэг, нислэгийн хөдөлгөөний удирдлагын холбооны ярианы бичлэг, холбогдох бичиг баримтуудыг авах шинжлэн шалгах ажиллагаанд оролцох бусад байгууллагуудын харилцааг зохицуулна.

1.4. Энэ журам нь агаарын хөлгийн осол, ноцтой зөрчил гарсан үед нислэгийн өгөгдөл, бүхээгийн яриа бичлэг, нислэгийн хөдөлгөөний удирдлагын холбооны ярианы бичлэг, холбогдох бичиг баримтуудыг нэн даруй авах, шинжлэн шалгах зорилготой.

## Хоёр. Нислэгийн бодит хяналтын төхөөрөмжүүдийн бичлэг тайлах ажиллагаа

### 2.1. Бичлэг тайлах ажиллагаанд оролцох

а) агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа явуулж буй улс нь тухайн агаарын хөлгийн бодит хяналтын төхөөрөмжийн бичлэг тайлах ажиллагаанд дараах улсын төлөөллийг оролцуулахыг зөвшөөрнө. Үүнд:

- зохион бүтээсэн улс

- үйлдвэрлэсэн улс

- оператор улсын итгэмжлэгдсэн төлөөлөгчид, мэргэжилтэн зэрэг орно.

Мөн томилогдсон багийн гишүүд, хүсэлтийн дагуу тоног төхөөрөмжөөр хангаж байгаа аливаа улсын мэргэжилтэн байна.

б) Шинжлэн шалгах ажиллагаанд тусалж байгаа итгэмжлэгдсэн төлөөлөгчид, гадаадын мэргэжилтэн нарын оролцоог үр дүнтэй болгох хэмжээнд бичлэг тайлах ажиллагаанд оролцохыг зөвшөөрөх,

в) Бичлэг тайлах ажиллагаанд шаардлага гарсан үед техникийн мэргэжилтнүүдийн туслалцаа авахаар татан оролцуулах,

г) Алба нь Монгол улсын нутаг дэвсгэрээс гадна Монгол улсад бүртгэлтэй агаарын хөлөгт тохиолдсон осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны явцад бичлэг тайлж унших ажиллагаанд оролцох,

е) Албанаас томилогдсон баг ба Монгол талын итгэмжлэгдсэн төлөөлөгч, зөвлөхүүд нь ослыг шинжлэн шалгах ажиллагааг явуулж байгаа улсын тодорхой илэрхийлсэн зөвшөөрөлгүйгээр шинжлэн шалгах ажлын явц ба бичлэг тайлсан байдал, илэрсэн зүйлүүдийн талаарх мэдээллийг задлахаас урьдчилан сэргийлнэ.

## 2.2. Ослын газар дээрх ажиллагаа

2.2.1. Агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийн шинжлэн шалгах ажиллагаа явуулж буй улс нь ИКАО-ын Хавсралт 13-ын "Attachmet D", Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны дүрэм"-ийн 4.6.1.5 заалтын дагуу нислэгийн бодит хяналтын төхөөрөмжүүдийг нэн даруй тайлж унших ажиллагааг зохион байгуулна.

2.2.2. Хэрэв осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа явуулж буй улсын хойшлуулшгүй шийдвэрлэх ажлын нэг бол бичлэг тайлах, анализ хийх үйл ажиллагааг хаана явуулахаа шийдэх юм, нислэгийн бичигчийг тайлж унших, хангалттай тоног төхөөрөмжгүй бол бусад улсуудаас тусламж авч ашиглах ёстой бөгөөд дараах зүйлсийг харгалзан үзнэ:

- а) бичлэг тайлж унших төхөөрөмжийн хүчин чадал;
- б) бичлэг тайлж унших ажиллагааг цаг тухайд нь хийх;
- с) бичлэг тайлж унших төхөөрөмжийн байршил зэрэг орно.

2.2.3. Бичлэгийг тайлж унших үйл ажиллагааг захиргааны, шүүхийн эсвэл санхүүгийн шалтгаанаар саатуулахгүй шуурхай явуулна.

2.2.4. Бичлэг тайлж унших ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг хоёр аргаар зохицуулна. Үүнд.

- Хамтран ажиллах санамж бичиг байгуулсан улс орнуудын тусламж дэмжлэг;
- Албаны тухайн жилийн төсөвт тусгагдсан шинжлэн шалгах ажиллагааны зардал.

2.2.5. Агаарын хөлгийн осол, ноцтой зөрчил гарснаас хойш аль болох богино хугацаанд бодит хяналтын төхөөрөмжийн бичлэгийг тайлж уншиж, болсон явдлыг олж тогтоох нь маш чухал байдаг. Доорх ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Бодит хяналтын төхөөрөмжийг хайж олж авах.
- Байгаа байдлын зургийг авч баталгаажуулах. Ослын газарт нислэгийн бодит хяналтын бичлэгийн төхөөрөмжийн хэрэгсэл хаанаас олдсоныг бүртгэж тэмдэглэнэ./Бичлэгийн төхөөрөмж нь тод улаан, улбар шар өнгөтэй, гадны нөлөө, гал уснаас хамгаалагдсан байна. 1100°C-ийн температурт 30 мин байх тэсвэртэй/.
- Бодит хяналтын төхөөрөмжүүдийн байрлаж буй газрын нөхцөл байдал, бичлэгт гэмтэл учирсан эсэхийг гадна байдлаас шалгаж тогтоох /тусгай зориулалтын төхөөрөмж ашиглан нислэгийн бичлэгийн төхөөрөмж дээр байдаг усан доорх байрлал тогтоох хэрэгслийн тусламжтай байрлалыг тогтоох, түүнийг гаргаж авах/.
- Бодит хяналтын төхөөрөмжийг бэлтгэх /Бодит хяналтын төхөөрөмжийг тээвэрлэлтэд бэлтгэх, аль болох түргэн хугацаанд аюулгүй хамгаалалтад тээвэрлэх, бичлэг тайлж унших лабораторид авчрах/

АГААРЫН ХӨЛГИЙН БОДИТ ХЯНАЛТЫН ТӨХӨӨРӨМЖҮҮД, НИСЛЭГИЙН  
ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН БИЧЛЭГИЙГ АВАХ, ХАМГААЛАХ, ХАДГАЛАХ ЖУРАМ

- Бичлэгийг тайлж унших. /Лабораторийн нөхцөлд өгөгдлийг татан хуулж авч, компьютерт өгөгдлийг оруулах, бичлэг тайлж унших, тайлан дүгнэлт гаргаж бичих/

### **2.3. Усанд дор байгаа бичлэгийн төхөөрөмж**

2.3.1. Агаарын хөлгийн бодит хяналтын төхөөрөмж нь далай, тэнгисийн усан дор байгаа бол бичлэгийн төхөөрөмжийг цаг алдалгүй олж илрүүлэхийн тулд Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах Алба нь холбогдох байгууллагууд мөн Монгол улсын гадна байгаа эх үүсвэрүүдэд хандах ёстой. Энэ талаар мэдэгдэхүйц туршлагатай бусад орнуудын ослыг шинжлэн шалгах байгууллагуудтай зөвлөх шаардлагатай.

2.3.2. Усанд орсон агаарын хөлгийн бодит хяналтын төхөөрөмжийн бичлэгийг тайлж унших ажиллагааг хаана хийх талаар төлөвлөгөө боловсруулан ажиллах ба бодит хяналтын бичлэгийн төхөөрөмжийн үйлдвэрлэгч, ашиглагчаас хамааран түүний бичлэгийг тайлж, унших ажиллагааг хаана хийх шийдвэрийг гаргана. Шинжлэн шалгах ажиллагаанд хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан улсууд болох ОХУ, БНСУ, БНФрУ-ын шинжлэн шалгах байгууллага руу хандан, тэдний FDR/CVR-ийн бичлэг тайлах лабораторид тайлж унших ажиллагааг хийж болно.

2.3.3. Тусгай зориулалтын төхөөрөмж ашиглан нислэгийн бичлэгийн төхөөрөмж дээр байдаг усан доорх байрлал тогтоох хэрэгслийн тусламжтай байрлалыг тогтоож, түүнийг гаргаж авах.

2.3.4. Ослын газарт нислэгийн бодит хяналтын бичлэгийн төхөөрөмжийг цэвэрлэх, угаах, хатаах ёсгүй. Давстай усанд дүрсний дараа бичлэгийн хэрэгслийг цэвэр усаар болгоомжтой зайлж, зэврэлт, идэгдлийг багасгахын тулд цэвэр усанд хийж хадгална. Тайлбар: Уснаас гаргаж авсан нислэгийн бодит хяналтын бичлэгийн төхөөрөмжийг усаар дүүргэсэн хөргөгч саванд тээвэрлэхэд тохиромжтой бөгөөд лабораторид мэргэжлийн хүмүүс цэвэрлэж хатаах хүртэл уснаас гаргаж болохгүй.

### **2.4. Шинжлэн шалгах багийн ахлагч**

2.4.1. Шинжлэн шалгах багийн ахлагч дараах үйл ажиллагааг зохион байгуулна.

- Агаарын хөлгийн ослын газар очиж, аль болохоор түргэн хугацаанд бүх холбогдох эд мөрийн баримт, бодит хяналтын төхөөрөмжүүдийг шалгах, хяналтдаа авах,

- Агаарын хөлгийн осол, ноцтой зөрчилтэй холбоотой мэдээ, мэдээллийг тээвэрлэгч, өмчлөгч, нисгэх баг, агаарын хөлгийн баг, ослын газар ажиллаж байгаа ажилтнууд болон бусад холбогдох хүмүүсээс шаардах

- Агаарын хөлгийн осол болсон газар, бусад шаардлагатай гэж үзсэн газарт нэвтрэх, агаарын хөлөгт суурилуулсан бодит хяналтын төхөөрөмжүүд FDR, CVR, QAR (цаашид "холбогдох төхөөрөмж" гэнэ)-тэй харьцах, түүнээс бичлэгийг хуулж авах,

- Агаарын хөлгийн осол, зөрчилд холбогдох хүмүүстэй (цаашид "холбогдох хүмүүс" гэж нэрлэнэ) уулзаж, асуулт асуух мэдүүлэг авах,

- Холбогдох материал буюу эд мөрийн баримтыг өмчлөгч, эзэмшигч, итгэмжлэгдсэн этгээдийг тэдгээр зүйлийг гаргаж өгөх ба хамгаалах, хадгалахыг шаардах,

АГААРЫН ХӨЛГИЙН БОДИТ ХЯНАЛТЫН ТӨХӨӨРӨМЖҮҮД, НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН БИЧЛЭГИЙГ АВАХ, ХАМГААЛАХ, ХАДГАЛАХ ЖУРАМ

- Агаарын хөлгийн осол болсон газар юм уу бусад осолтой холбоотой газарт нэвтрэх,
- Холбогдох материал буюу эд мөрийн баримт, FDR, CVR, QAR-ийн холболт, суурилалт, ажлын бэлэн байдлыг хөндлөнгийн оролцоогүйгээр сайтар судалж шалгах,
- Агаарын хөлгийн бодит хяналтын төхөөрөмжүүдийг шаардлагатай тохиолдолд бичлэг тайлж унших лабораторид саадгүй авч ирэх,

2.4.2. Бичлэг тайлж унших лабораторид явагдаж буй үйл ажиллагааны явц, агаарын хөлгийн бодит хяналтын төхөөрөмжийн бичлэгийн талаарх мэдээллийг бусдад дамжуулах болон дэлгэхгүй байх,

2.4.3. Ослоос урьдчилан сэргийлэхээс бусад зорилгоор FDR, CVR-ийн дараах бичлэгийг дэлгэхгүй байх үүрэгтэй. Үүнд:

- Ослыг шинжлэн шалгах ажлын явцад холбогдох хүмүүсийн шинжлэн шалгах Албанд өгсөн мэдээлэл,
- Нислэгийн үйл ажиллагаанд оролцож байсан хүмүүсийн хоорондын яриа,
- Аливаа мэдээллийн талаарх санал дүгнэлт тэр дундаа агаарын хөлгийн бичлэгийн төхөөрөмжийн бичлэгийн талаарх дүн шинжилгээ

## **2.5. Техникийн лабораторийг сонгох**

2.5.1. Шинжлэн шалгах ажиллагаа явуулж буй улс нь боломжтой гэж үзсэн ямар ч улсад хандаж хүсэлт гаргаж болно.

2.5.2. Энгийн стандартын бичлэг сэргээх унших программ хангамж нь шинжлэн шалгах ажиллагаанд таарахгүй яагаад гэвэл бичлэгийн төхөөрөмж нь осол, зөрчлийн үед гэмтсэн байж болох тул тусгай зориулалтын тоног төхөөрөмжтэй байх ёстой.

2.5.3. Техникийн лаборатори нь дараах тоног төхөөрөмж, хэрэгслээр хангагдсан байх ёстой. Үүнд:

- a) ноцтой эвдэрч гэмтсэн бодит хяналтын төхөөрөмжийг задалж, сэргээх боломжтой, түүний бичлэгийг тайлж унших боломжтой байх
- b) осол, зөрчлийн үеийн эх бичлэгийг сэргээн босгох боломжтой, задаргаа хийж түүний санах ойг салган авч бичлэгийг сэргээн унших боломжтой байх
- c) гэмтсэн туузад дээр бичигдсэн нислэгийн өгөгдөл, хоёртын сигналын хэлбэлзлийг сэргээн босгож, бичлэг тайлж, анализ хийх боломжтой байх
- d) тохирох программ хангамж ашиглан дуун сигнал, яриаг шүүж сонсох, өсгөх боломжтой байх.
- e) өгөгдлийг графикаар үзүүлж, анализ хийх, нэмэлт параметруудийг харах, бусад аргаар өгөгдлийн харгалзах хязгаарт гарцаагүй байдлыг баталгаажуулах боломжтой байх.

## **2.6. Үйлдвэрлэгч ба оператор улсын оролцоо**

2.6.1. Үйлдвэрлэгч (эсвэл угсарсан) улс нь нислэгт тэнцэх чадварын талд хариуцлага хүлээдэг тул бичлэгийн төхөөрөмжийн өгөгдлийн бичлэг тайлах ажиллагаанд мэргэжлийн боловсон хүчнээр хангаж болно.

2.6.2. Бодит хяналтын төхөөрөмжид бичигдсэн мэдээлэл нь үйлдвэрлэгч улсад нислэгт тэнцэх чадвартай холбоотой асуудлуудыг гаргаж ирэх, тодруулах боломж олгодог тул үйлдвэрлэгчид харьяалахгүй улсад явагдаж буй нислэгийн

АГААРЫН ХӨЛГИЙН БОДИТ ХЯНАЛТЫН ТӨХӨӨРӨМЖҮҮД, НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН БИЧЛЭГИЙГ АВАХ, ХАМГААЛАХ, ХАДГАЛАХ ЖУРАМ бичлэг тайлах ажиллагаанд оролцуулахаар өөрийн төлөөлөгчийг илгээх хэрэгтэй байдаг.

2.6.3. Оператор улс нь нислэг үйлдвэрлэлийн дүрэм журмын дагуу хариуцлага хүлээдэг тул ашиглагчийн үйл ажиллагаанд шууд бус харилцаатай байдаг оператор улсын хувьд анализ хийх ажиллагаанд тусламж үзүүлж болох юм.

2.6.4. Агаарын хөлгийн нислэгийн бичлэгийн төхөөрөмжид бичигдсэн бичлэгийн мэдээлэл нь ашиглалттай холбоотой асуудлыг хурдан хугацаанд тодорхойлж гаргаж ирэхэд тусалдаг тул ашиглагч улсын төлөөлөл нь бичлэг тайлах ажиллагаанд оролцох шаардлагатай.

## **2.7. Үйл ажиллагааны зөвлөмж**

2.7.1. Агаарын хөлгийн нислэгийн өгөгдөл бичигч, бүхээгийн яриа бичлэгийн төхөөрөмжүүдийн бичлэг тайлж унших ажиллагааг нэг техникийн лабораторид хийж гүйцэтгэх хэрэгтэй. Учир нь өгөгдлүүдийн бичлэг нь дэс дараалал, цаг хугацааны хувьд өөр хоорондоо уялдаа холбоотой, нэг нь нөгөөгөө бататгаж байдаг тул ингэх нь тодорхой үр дүн үзүүлэх ач холбогдолтой байдаг.

2.7.2. Бодит хяналтын төхөөрөмжийн бичлэгийг тайлж уншихын өмнө түүнийг задлах болон түүнд цахилгаан тэжээл залгах, хуулбарлах (ялангуяа өндөр хурдны хуулбарлах төхөөрөмжөөр хуулбарлахыг хориглоно) ажиллагааг хийж болохгүй. Энэ нь бичлэгийг гэмтээх эрсдэлтэй.

2.7.3. Өөр улсын нислэгийн бичлэгийн төхөөрөмжийн бичлэг тайлж уншсан техникийн лаборатори нь эцсийн тайланд санал бодлоо илэрхийлэх боломжийг олгоно.

2.7.4. Бичигдсэн мэдээллийг баталгаажуулах, тохируулгын өгөгдлүүдийг шалгах зорилгоор агаарын хөлгийн үйлдвэрлэгч болон ашиглагчаас мэргэжлийн тусламж авах шаардлага бичлэг тайлах ажиллагааг явуулж буй техникийн лабораторид гарч болно.

2.7.5. Шинжлэн шалгах ажиллагааг явуулж буй улс нь нэмэлт асуулт, хүсэлт, тодруулах нөхцөл гарч ирж болзошгүй тул бичлэг тайлсан техникийн лабораторид бичлэгийн эх хувь болон хуулбарыг шинжлэн шалгах ажиллагааг дуустал хадгалан үлдээж болно. Уг лаборатор нь Бичлэгийг хамгаалах хангалттай аюулгүй байдлын журамтай байна.

## **2.8. Техник хэрэгсэл**

2.8.1. Бодит хяналтын төхөөрөмжийн бичлэг тайлж уншихад зориулагдсан тоног төхөөрөмж, тэжээлийн блок, цахилгаан гүйдлийн давтамж хувиргагч гэх мэт бүрэн тоноглогдсон байна.

2.8.2. Агаарын хөлөгт тоноглогдсон бодит хяналтын төхөөрөмжийн төрөл, маягаас хамааран тохирох маркийн дамжуулагч кабель, холбох залгуур, мэдээлэл хуулагч компьютер, түүнд суулгагдсан бүх төрлийн FDR/CVR-ийн мэдээллийг татаж авах зориулалтын программ хангамжтай байна.

2.8.3. Тухайн улсад ашиглагдаж буй бүх төрлийн агаарын хөлгийн нислэгийн өгөгдлийг тайлж унших зориулалтын программ хангамж, агаарын хөлгийн

АГААРЫН ХӨЛГИЙН БОДИТ ХЯНАЛТЫН ТӨХӨӨРӨМЖҮҮД, НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН БИЧЛЭГИЙГ АВАХ, ХАМГААЛАХ, ХАДГАЛАХ ЖУРАМ тогтмол үзүүлэлт бүхий өгөгдлүүдийн файл, стандартын заавар, журам бүхий бичиг баримтуудтай байна.

2.8.4. Нислэгийн бичлэг тайлж унших лаборатори нь зохих журмын дагуу статик болон цахилгаан гүйдлээс хамгаалсан газардуулгатай орчинтой байна.

## **2.9. Бичлэг тайлах ажиллагаанд оролцогчдын хувийн хамгаалалтын хэрэгсэл**

- Хамгаалалтын хэрэгслийг ослын газраас гадуур лабораторийн нөхцөлд бичлэг тайлах ажиллагаа явуулж байгаа үед хэрэглэх шаардлагатай байж болно. Статик болон цахилгаан гүйдэл, соронзон орноос зохих шаардлагын дагуу хамгаалах сургалт ба тоног хэрэгслийн асуудлаар мэргэжлийн байгууллагуудад хандаж тэдгээрээр хангуулах арга хэмжээг авна.

- Тоног төхөөрөмжтэй харьцах, тэжээлийн блок, цахилгаан эх үүсвэрүүдтэй ажиллах зэрэгт хамгаалалтын бээлий хэрэглэнэ.

- Статик гүйдлээс хамгаалсан зориулалтын бугуйвч, гутлын улны хамгаалалт хэрэглэх

- Бохирдсон материалтай шууд хүртэлцэх лабораторийн ажиллагсад нь латекс /резин нимгэн/ бээлийг ажлын бээлийн дотуур өмсөх боловч тэдгээр нь эдэлгээ даахаар байх ёстой. Хэрэглэсний дараа зохих журмын дагуу хаях ёстой.

- Ажлын бээлий нь эдэлгээ сайтайгаас гадна хэрэглэхэд тохиромжтой байх бөгөөд гар ба бугуйг хатгуулах, шАлбарахаас хамгаалах ёстой.

- Нэг удаагийн улавч. Лабораторид орохдоо пластмас юм уу резинээр хийсэн нэг удаагийн улавчийг хэрэглэх нь тохиромжтой.

- Ариутгалын бодис. Хувийн хамгаалалтын хэрэгслийг ариутгахад хоёр төрлийн химийн бодисыг өргөн хэрэглэдэг. Спиртийн 70%-ийн уусмал үр дүнтэй бөгөөд жижиг болон том гарын алчууранд шингээсэн байдлаар байдаг. Хамгийн үр дүнтэй ариутгалын уусмал бол ердийн ахуйн хлорамин ба усны аравны нэгийн харьцаатай уусмал юм. Спирт ба хлораминийг хэзээ ч хольж болохгүй.

- Хувийн хамгаалалтын иж бүрэн хэрэгсэл. Хувийн хамгаалалтын иж бүрэн хэрэгсэл нь хүн бүрт байх ёстой. Иж бүрэн хэрэгсэлд бие бүрэн хаах хамгаалалтын хослол, хэдэн хос латекс бээлий, ажлын бээлий, нүүрний маск, нүдний шил, улавч ба хамгаалалтын гутал, ариутгалын бодис зэрэг орно.

- Бохирдсон шинжилгээний төхөөрөмжүүд. Багаж хэрэгсэл, гар чийдэн, туузан метр зэрэг бохирдсон шинжилгээний төхөөрөмжүүдийг савантай усаар угааж ариутган хатаах ёстой. Шууд ариутгах боломжгүй төхөөрөмжүүдийг биологийн аюултай хаягдлын уутанд хийнэ. Хаягдлын уут ба түүн дотор байгаа зүйлсийг эмнэлэг зэрэг зохих газар шатаах ёстой.

## **2.10. Гэмтсэн бичлэгийн төхөөрөмж**

- Нислэгийн бодит хяналтын төхөөрөмжийн хэрэгсэл түүний ил гарсан хэсэгтэй маш болгоомжтой харьцаж бичигдсэн мэдээлэл устаж алга болохоос сэргийлэх. Бичлэгийн хэрэгсэл эвдэрсэн бол аль болох олон хэсгийг цуглуулна.

- Цахим хэлхээг болгоомжтой цуглуулж, шошго бүхий цахилгаан цэнэг үүсэхгүй/антистатик/ гялгар уутанд хадгална.

- Бичлэгийн хальс тасарсан байсан ч буцаан эвлүүлэх боломжтой тул аль болохоор их соронзон хальсыг цуглуулна.

- Гэмтэж шатсан бичлэгийн төхөөрөмжийг тусгай зориулалтын тоног төхөөрөмж бүхий лабораторид авчран задаргаа хийн memory chip, санах ой

зэрэг гол эд ангийг салган авч түүнээс мэдээлэл, бичлэгийн өгөгдлийг сэргээн авах ажиллагааг хийдэг.

- Гэмтсэн бичлэгийн төхөөрөмжийн бичлэгийг сэргээн босгох үйл ажиллагааг хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр бүхий улсуудын шинжлэн шалгах лабораторид хүргүүлэн хийнэ.

- Агаарын хөлөг, түүний бодит хяналтын бичлэгийн төхөөрөмжийн үйлдвэрлэгч, ашиглагчаас хамааран түүний бичлэгийг тайлж, унших ажиллагааг хаана хийлгэх талаар төлөвлөгөө зохион ажиллана. Үүнд: Хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан улсууд болох ОХУ, БНСУ, БНФрУ-ын шинжлэн шалгах байгууллагын FDR/CVR-ийн бичлэг тайлах лабораторид уншуулж болно.

#### **2.11. Бодит хяналтын төхөөрөмжийн зургийг авч баталгаажуулах, хамгаалалтад авах**

- Шинжлэн шалгах Алба нь осол, ноцтой зөрчилд орсон агаарын хөлгийн бодит хяналтын төхөөрөмжийг хяналтандаа авч галын аюул ба нэмж гэмтэхээс сэргийлэх, фото зураг болон бусад зохих арга хэрэгслийн тусламжтайгаар баримтжуулах арга хэмжээ авах,

- Шаардлагатай бол холбогдох дүрэмд заагдсанаар Алба нь бодит хяналтын төхөөрөмжүүдийг өөрийн хамгаалалтанд авна.

- Бичлэгийн хэрэгслийг шилжүүлэх хамгаалалтыг бүрдүүлж, бүртгэл хөтөлнө.

- Хамгаалалтын үргэлжилсэн байдлыг тасалж болохгүй.

#### **2.12. Бодит хяналтын төхөөрөмжүүдийг шалгах**

- Бодит хяналтын бичлэгийн төхөөрөмж байрлаж буй газрын нөхцөл байдал, бичлэгт гэмтэл учирсан эсэхийг гадна байдлаас шалгаж тогтооно.

- Бодит хяналтын бичлэгийн төхөөрөмжийн оролт, гаралтын портын гэмтэл, мэдээлэл хуулах, татах холболтын кабелийн бүрэн бүтэн байдлыг шалгах

- Осол, ноцтой зөрчил болсон газрын нөхцөл байдал ба байрлал нь тухайн агаарын хөлгийн бодит хяналтын төхөөрөмжийн бичлэгийг тайлж, унших боломжтой юу үгүй юу гэдгийг шийдэхэд нөлөөлнө. Нислэгийн өгөгдлийн бичлэг нь агаарын хөлгийн аюулгүй байдалд чухал баримтыг агуулж байгаа тул ослыг шинжлэн шалгах эрх бүхий байгууллага нь Бодит хяналтын төхөөрөмжийг түргэн шуурхай гаргаж авахуулахын тулд шаардлагатай түлхцийг өгөх ёстой.

#### **2.13. Бодит хяналтын төхөөрөмжийг бэлтгэх**

- Бодит хяналтын бичлэгийн төхөөрөмжийг цаг алдалгүй яаралтай шинжлэн шалгах Албаны бичлэг тайлах лабораторид авч ирэн гэмтлийг тогтоож, бичлэг тайлж унших боломжтой эсэхийг тодорхойлно.

- Хэрвээ агаарын хөлөг ба бодит хяналтын төхөөрөмжийн үйлдвэрлэгч, зохион бүтээгч, эцсийн угсралт хийсэн улс, ашиглагчийн талаас хүсэлт гаргасан тохиолдолд түүнийг ирж шалгалт хийх хүртэл агаарын хөлгийн бодит хяналтын бичлэгийн төхөөрөмжийг оролдох ба хөдөлгөж зөөвөрлөхгүйгээр байлгана. Энэхүү заалт нь ямарч үед ослыг шинжлэн шалгах Албаны зүгээс явуулах шинжлэн шалгах ажиллагаанд нөлөөлөхгүй байх ёстой ба иргэмжлэгдсэн төлөөлөгч ирэхээс өмнө түүнд урьдчилан мэдэх боломжгүй шалтгаанаар агаарын хөлөг ба бусад зүйлийг шилжүүлэн хөдөлгөх юмуу бусад хэлбэрээр

АГААРЫН ХӨЛГИЙН БОДИТ ХЯНАЛТЫН ТӨХӨӨРӨМЖҮҮД, НИСЛЭГИЙН  
ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН БИЧЛЭГИЙГ АВАХ, ХАМГААЛАХ, ХАДГАЛАХ ЖУРАМ

оролдох шаардлага гарвал үйл ажиллагааг фото зураг ба бусад зохих аргаар баримтжуулна.

- Гэмтлийн талаар тодорхой дүгнэлт гарган хаана бичлэг тайлах ажиллагааг явуулах боломжтойг урьдчилан тогтооно.

- Бодит хяналтын төхөөрөмжүүдийн төрлөөс хамаарч үйлдвэрлэсэн ба баталгаажуулсан, зохион бүтээсэн, эцсийн угсралт хийсэн улс, ашиглагч улс зэрэг холбогдох газраас бичлэг тайлахад шаардлагатай баримт бичиг, холбогдох материалыг гаргуулж авах,

- Агаарын хөлгийг зохион бүтээсэн ба үйлдвэрлэсэн улс (зохион бүтээсэн ба эцсийн угсралт хийсэн байгууллага), тээвэрлэгчийг харъяалах улсаас тухайн агаарын хөлгийн нислэгийн өгөгдлийн параметруудийн стандарт бичиг баримт, холбогдох материалыг шаардаж авах,

- Бичлэг тайлах ажиллагааг удирдан явуулж байгаа улсыг дараах зүйлүүдээр хангана. Үүнд:

- тухайн улсаас хүссэн бүх осолтой холбоотой мэдээлэл,

- осол, ноцтой зөрчил тохиолдохоос өмнө тухайн агаарын хөлгийн бодит хяналтын төхөөрөмжийн ашигласан болон ашиглаж байсан байгууллагын мэдээллүүдийг,

- агаарын хөлгийн ашиглагч талаас тухайн агаарын хөлгийн сүүлийн 6 сарын турших хийсэн нислэгийн бичлэгийг,

- агаарын хөлгийн бүртгэгдсэн эсвэл тээвэрлэгчийн харъяалагдах улсын хувьд тухайн агаарын хөлгийн урьд өмнө осол болон ноцтой зөрчилд орж байсантай холбогдолтой нислэгийн бодит хяналтын төхөөрөмжийн бичлэгүүд.

- Тээвэрлэлт хийхийн өмнө бодит хяналтын бичлэгийн төхөөрөмжийг тусгай саванд хийн, лацдаж таних тэмдэг тавин Хавсралт 1-ийн дагуу маягт бөглөн хариуцаж буй хүнд хүлээлгэн өгнө.

#### **2.14. Бодит хяналтын төхөөрөмжийг тээвэрлэх**

- Тээвэрлэх болон хадгалах явцад бодит хяналтын бичлэгийн төхөөрөмжийг шинжлэн шалгах ажиллагаа явуулж буй шинжлэн шалгах багийн ахлагчийн томилсон хүн хариуцан авч явна.

- Бодит хяналтын бичлэгийн төхөөрөмжийг гадаад улсын бичлэг тайлах лаборатор луу явуулах тохиолдолд Албан ёсны зөвшөөрөлтэй тээврийн компаниар үйлчлүүлнэ. Жишээ нь: DHL, Монгол шуудан.

- Агаарын хөлөг, түүний бодит хяналтын бичлэгийн төхөөрөмжийн үйлдвэрлэгч, ашиглагчаас хамааран түүний бичлэгийг тайлж, унших ажиллагааг хаана хийх талаар төлөвлөгөө зохион ажиллана. Хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан улсууд болох ОХУ, БНСУ, БНФрУ-ын шинжлэн шалгах байгууллагын FDR/CVR-ийн бичлэг тайлах лабораторид уншуулж болно.

- Бодит хяналтын бичлэгийн төхөөрөмж нь усанд байсан тохиолдолд тухайн далай, нуур, голын усанд нь хийж тусгай саванд байрлуулж авч явна.

- Бодит хяналтын төхөөрөмжийг аль болох түргэн хугацаанд аюулгүй хамгаалалтанд тээвэрлэх, бичлэг тайлж унших лабораторид авчрах

- агаарын хөлгөөс нислэгийн бодит хяналтын бичлэгийн хэрэгслийг Ослыг шинжлэн шалгах Албаны лаборатори руу тээвэрлэхийн тулд, тусгай хайрцагт хийж авч явна.

- Дараахи зүйлүүд нь нислэгийн бодит хяналтын бичлэгийн төхөөрөмжийн бичлэгийг устгах шалтгаан болж болно.

- Статик орчин

- Хангалтгүй баглаа боодол

- Цохилт
- Бичлэгийн төхөөрөмжүүдийг эцсийн тээвэрлэлтэнд бэлдэх үедээ тохирох хайрцаг сав ба шошго хэрэглэнэ. Тээвэрлэлтийн чиглэл нь товч бөгөөд тодорхой, тээвэрлэлтийн чухал асуудал ба бусад холбогдох нөхцөл байдлыг заасан байна. Тээвэрлэлтийн явцыг тасралтгүй хянахад шаардлагатай гэж үзвэл тээвэрлэлтэнд бэлдсэн ачаа, хайрцаг, савны фото зургийг авч, ачааны хөдөлгөөнийг бүртгэх дэвтрийг нээнэ.
- Тээвэрлэлтийн зохион байгуулалтыг хийхдээ, бичлэгийн төхөөрөмж нь шинжилгээний лабораторид очихдоо ослын газар олдсонтой ижил нөхцөлд байх ёстой. Дараах зүйлүүдийг анхаар.
  - харуул хамгаалалтын шаардлагатай арга хэмжээг авсны дараа бичлэгийн төхөөрөмжүүд нь бүрэн бүтэн тээвэрлэх явдлыг баталгаажуулах ёстой.
  - Жижиг эд ангиудад битүүмжилсэн давхар уут ба Албаны лацыг хэрэглэнэ.
  - Утсан лац зэрэг шаардлага хангасан танигдахуйц лац хэрэглэнэ.Тээвэрлэлтийн компани нь дараах шаардлагыг хангах ёстой.
- Найдвартай
- Нэр хүндтэй
- Тээвэрлэлтийн бүх үеүдэд ачааны аюулгүй байдал ба хамгаалалтыг хариуцах чадвартай
- Тээврийн компани нь дараах зүйлүүдийг эзэмшсэн байх ёстой.
  - Тогтсон шаардлага хангахуйц бүртгэлийн систем
  - Замын дагуу цоожтой, хамгаалалттай хашаа байшин юм уу эцсийн зогсоолын хадгалах байгууламж
- Тухайн бичлэгийн төхөөрөмж нь алдагдсан юм уу гэмтсэн тохиолдолд шинжлэн шалгах ажиллагаанд ноцтой саад учруулахаар шинжилгээний чухал ач холбогдолтой бол тухайн бичлэгийн төхөөрөмжийг тусгай хамгаалагчаар хамгаалуулж илгээх арга хэмжээг авна.
- Тээвэрлэлтийн гэрээлэгч талд хяналтын маягыг өгч, хүлээн авсан, зөвшөөрсөн гарын үсэг зуруулна.

## **2.15. Бодит хяналтын төхөөрөмжийн бичлэгийг тайлж, унших**

- Лабораторийн нөхцөлд өгөгдлийг татан хуулж авч, компьютерт өгөгдлийг оруулах, бичлэг тайлж уншихад бэлтгэнэ.
- Шаардлагатай тохиолдолд бодит хяналтын төхөөрөмжийг зааврын дагуу агаарын хөлгөөс салган авч, бичлэг тайлах лабораторид авчран бичлэг тайлах ажиллагааг явуулна.
- Агаарын хөлгийн бодит хяналтын төхөөрөмжүүд гэмтээгүй хэвийн ажиллаж байвал шууд өгөгдлийг хуулж авах ажиллагааг явуулна.
- Агаарын хөлгийн бодит хяналтын төхөөрөмжөөс өгөгдлийг хуулж авахдаа зориулалтын RSU II компьютерыг ашиглах бөгөөд FDR-ийн төрөл, маягаас хамаарч тохирох дамжуулалтын залгуурыг хэрэглэнэ. Энэ тохиолдолд агаарын хөлгийн хөдөлгүүрийг унтраасан байх ба бодит хяналтын төхөөрөмжийг 115V, 400Гц-ийн давтамжтай цахилгаан тэжээлээр хангасан байна.
- Агаарын хөлгийн бодит хяналтын төхөөрөмжүүд нь гэмтэж, нислэгийг өгөгдлүүдийг шууд татан авах боломжгүй тохиолдолд тухайн бодит хяналтын төхөөрөмжийг агаарын хөлгөөс салган авч бичлэг тайлах лабораторид тусгай нөхцөл байдалд задлан унших арга хэмжээг авч явуулна.
- Хэрэв тухайн агаарын хөлөг нь Quick Access Recorder (QAR) –аар тоноглогдсон бол нислэгийн өгөгдлийг QAR-аас татан авч, бичлэг тайлж, унших ажиллагааг зориулалтын тохирох программ хангамжийн тусламжтай хийж болно.

АГААРЫН ХӨЛГИЙН БОДИТ ХЯНАЛТЫН ТӨХӨӨРӨМЖҮҮД, НИСЛЭГИЙН  
ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН БИЧЛЭГИЙГ АВАХ, ХАМГААЛАХ, ХАДГАЛАХ ЖУРАМ

- Ослыг шинжлэн шалгах Алба нь өөрийн мэргэжлийн чадварыг дээшлүүлэх ба бичлэг тайлж унших, боловсруулах ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд холбогдох программ хангамж, тоног төхөөрөмжөөр хангах байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулсан байна.

- Бодит хяналтын төхөөрөмжийг бичлэг тайлах лабораторид авчран, 115V, 400Гц-ийн давтамж бүхий тэжээлд холбох бөгөөд өгөгдөл татаж авах зориулалтын тоног хэрэгсэл RSU II-ийн тусламжтайгаар өгөгдлийг хуулж авч, Insight recovery программ хангамжийн тусламжтай сэргээн босгох ажиллагаа хийгдэнэ.

- Лабораторийн нөхцөлд бодит хяналтын төхөөрөмжийн бичлэгийг хуулж авах боломжгүйгээр гэмтсэн бол гадаад орны тусгай зориулалтын тоноглогдсон лабораторид бодит хяналтын төхөөрөмжийг авчран бүрэн задаргаа хийж, гэмтэж эвдрээгүй эд ангийг салган авч түүнээс өгөгдлийг хуулж гарган авах ажиллагааг хийнэ.

## 2.16. Бичлэг тайлж уншсан тайлан бичих

- Бичлэг тайлах ажиллагааг гүйцэтгэж дууссаны дараа бичлэг тайлагч ба шинжлэн шалгах байгууллагын ажилтнууд үр дүнг хянаж хэлэлцэх ёстой. Нислэгийн өгөгдлөөс авсан мэдээлэл нь тухайн агаарын хөлгийн нислэгийн нөхцөл байдал ба нислэгийн үзүүлэлтийн талаар харуулсан баримт бичгийн үйлдэж, бичлэг тайлж уншсан талаар тайлбар хийж, анализ хийсэн үр дүнгийн талаар хүснэгтэд мэдээлэл, график зурган мэдээлэл, хөдөлгөөнт дүрслэл зэрэг боломжит бүх аргаар тухайн агаарын хөлгийн нислэгийн талаарх мэдээллийг гаргаж өгнө.

- Агаарын хөлгийн нислэгийн бичлэг тайлж уншсан тайланг Аннекс 13-ын С нэмэлт хавсралтад заасан шаардлагын дагуу бичнэ.

- Тайланд тавигдах шаардлага нь бүх төрлийн иргэний нисэхийн осол, ноцтой зөрчилд адил байна.

- Шинжлэн шалгах Албаны бичлэг тайлах ажиллагаа хариуцсан ажилтан нь нислэгийн бичлэг тайлсан үйл ажиллагааны тайланг гаргана. Тайлангийн формат ба агуулга нь Олон улсын иргэний нисэхийн конвенцын 13-р хавсралт, 6-р хавсралтын баримт бичигтэй нийцсэн байна. Тайлангийн хэмжээ, цар хүрээ нь ослын нөхцөл байдал ба холбогдох агаарын хөлгийн маяг, бодит хяналтын төхөөрөмжүүдийн төрлөөс хамаарна. Гэхдээ Монгол улсаас гадна бүртгэгдсэн, үйл ажиллагаа явуулдаг, зохион бүтээсэн, үйлдвэрлэсэн агаарын хөлөг оролцсон бүх осол нь Олон улсын иргэний нисэхийн байгууллагын шаардлагатай бүрэн нийцсэн байна.

- Тайланг аль болохоор түргэн гаргах нь шинжлэн шалгах Албаны бодлого байна. Гаргасан тайланг Албаны веб сайтаар дамжуулж, олон нийт, мөн шинжлэн шалгах ажиллагаанд оролцогч аливаа улс оронд болон Олон улсын иргэний нисэхийн байгууллагад өгнө.

- Нислэгийн бичлэг тайлах үйл ажиллагааны эхлэхийн өмнө, ерөнхий шинжлэн шалгагч нь тайланг гаргаж дуусах хугацааг тооцсон тайлангийн хуваарийг гаргуулна. Төлөвлөсөн хугацаа нь тухайн ослын нарийн төвөгтэй байдал ба агаарын хөлгийн холбогдох аюулгүй байдлын асуудлуудаас хамаарна.

- Хамгийн бага аюулгүй байдлын асуудал бүхий бага хэмжээний ослын бичлэг тайлсан тайланг гаргаж дуусах нь осол болсноос хойш 1 сар байна. Нарийн төвөгтэй аюулгүй байдлын асуудал бүхий томоохон ослын тайланг гаргаж дуусах хугацаа нь 1 жил юм уу аль болох хурдан байх ёстой.

- Зарим шалтгаанаар бодит хяналтын төхөөрөмжийн бичлэгийг тайлж унших ажиллагааны тайланг осол болсон өдрөөс хойш 1 жилийн хугацаанд гаргах боломжгүй бол ахиц ба үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан явцын тайланг гаргана.

## 2.17. Тайлангийн формат

- Оршил. Оршлын хэсэг нь ослын товч мэдээлэл ба агаарын хөлгийн маяг, үйлдвэрлэсэн он, ашиглагч байгууллага, авиакомпаний талаарх мэдээллийг оруулсан байна. Тухайн агаарын хөлгийн бодит хяналтын төхөөрөмжүүдийн нэр, төрөл, partnumber, сериал дугаар, FDAU, QAR-ийн нэр, төрөл, part number, сериал дугаар, техникийн үзүүлэлтүүдийг жагсаан бичнэ. Энэ хэсэгт мөн бодит хяналтын төхөөрөмжийн нислэгийн бичлэг тайлж, унших үйл ажиллагааны хугацаа, байрлалын талаарх товч мэдээллийг оруулна.

- тайлан нь дараах мэдээллүүдийг агуулсан гарчгаар эхэлнэ: Үйл ажиллагаа явуулагчийн нэр, үйлдвэрлэгч, загвар, харьяалал ба бүртгэлийн дугаар, осол, зөрчил гарсан газар ба он сар өдөр.

- Дараах бүх мэдээллийн талаар товчхон танилцуулна: ослыг шинжлэх шалгах ажиллагааг зохион байгуулах тайланг гаргаж байгаа эрх бүхий байгууллага ба нийтэлсэн өдөр, эцэст нь осолд хүргэсэн нөхцөл байдлын товч дүгнэлт

- Үндсэн хэсэг нь дараах гарчгуудтай байна.

- Баримтат ерөнхий мэдээлэл
- Шинжилгээ
- Дүгнэлт

- Гарчиг болгон нь доор бичсэний дагуу хэд хэдэн дэд гарчгаас бүрдэнэ. Шаардлагын дагуу хавсралтыг оруулна. Тайлбар: Энэ форматыг ашиглан эцсийн тайланг бэлдэхдээ зүйлүүдийг анхаарна. Баримтат мэдээ мэдээлэл, шинжилгээ, дүгнэлтийн талаарх ойлголтод хамааралтай бүх мэдээллийг тохирох гарчгийн доор нэгтгэнэ.

- Нислэгийн түүхийг баримтжуулахын тулд дараах мэдээллүүдийг цуглуулна.

1) агаарын хөлгийн өмчлөгч ба ашиглагчийн нэр, хаяг, телефон утасны дугаар

2) агаарын хөлгийн төрөл

3) бүртгэлийн дугаар ба серийн дугаар

4) нислэгийн дугаар

5) үйл ажиллагааны төрөл /дотоодын агаарын тээврийн компани гэх мэт/

6) осол болсон өдөр цаг ба ослын газрын байрлал /өргөрөг, уртраг, өндөр/, хөөрсөн, буух цэг, алслалт зай

7) хамгийн сүүлд хөөрсөн газар, блок ба хөөрөлтийн цагийг авах

8) замын явц дах зогсолтууд, блок ба хөөрөлтийн цагийг авах

9) төлөвлөсөн буух цэг

10) чиглэлээсээ хазайж, төлөвлөөгүй цэгт буусан

11) нислэгийн төлөвлөгөөний, эх хувийг үзэж батлагдсан хуулбарыг олж авах

12) Зөвшөөрөл авсан байдал. Баталгаат хувийг хуулж авах. НХУ-ын бичлэгийн хэсэг томилогдоогүй бол бичлэгийн эх хувийг сонсоно.

13) тухайн үед ниссэн ба ердийн үед нисдэг зам ба нислэгийн өндөр, багийн гишүүдийн нислэгийн замыг мэдэх байдал

14) нислэгийн явц дахь оператор ба НХУ-тай тогтоосон радио холбоо /байгууламж ба давтамж/, баталгаажсан хуулбар ба бичлэгийг олж авна.

- Өөр улс орнууд явуулж байгаа шинжлэн шалгах ажиллагаанд Монгол улс оролцож байгаа тохиолдолд Алба нь бусад улсуудаас 13-р хавсралт өгсөн эцсийн тайлангийн эх хувийн талаарх тайлбараа аль болох хурдан гаргаж өгнө.

- Алба нь бичлэг тайлсан тайлангийн эх хувийг зөвлөлдөх зорилгоор өөр улсаас авсан тохиолдолд тухайн тайлан юм уу шинжлэн шалгах ажиллагааны явцад олж авсан бусад бичиг баримтыг шинжлэн шалгах ажиллагааг явуулж байгаа улс орны зөвшөөрөлгүйгээр тараах, хэвлэн нийтлэх болон бусад хэлбэрээр тайланд нэвтрэхээс сэргийлэх бүх арга хэмжээг авна. Мэдээж эдгээр тайлан ба бичиг баримтуудыг нөгөө улс нь нийтэлсэн тохиолдолд Алба нь эдгээрийг мөн гаргаж болно. Гэхдээ зөвшөөрөөгүй материалыг дэлгэхгүй байхад анхаарах ёстой.

- тайланг дуусгах үед Алба нь тайлангийн хуулбаруудыг шинжлэн шалгах ажиллагаанд оролцсон бүх улс орнууд, өөрийн иргэн нь амь насаа алдсан юм уу ноцтой гэмтсэн улс орнууд, холбогдох мэдээллээр хангасан улс орон, чухал байгууллагууд юм уу мэргэжилтнүүд, Олон улсын иргэний нисэхийн байгууллагад /5700 кг-ээс жинтэй агаарын хөлгийн хувьд/ нэн даруй илгээнэ.

- Алба нь тайланг олон нийт ба Албан байгууллагуудад тараахын тулд цаасан дээр хэвлэнэ. Тайланг мөн олон нийтэд өгөх зорилгоор АЛБА-ны вэб сайтад цахим хэлбэрээр байрлуулна.

- Бодит хяналтын төхөөрөмжөөс авсан нислэгийн бүх өгөгдлийг тусгай зориулалтын Insight программын тусламжтай боловсруулж, хүснэгтэн болон график зургаар тухайн программын стандарт форматын дагуу гаргана.

- нислэгийн турш болсон явдал, нислэгийн параметруудийн үзүүлэлтийг судалж анализ хийсэн байдал зэргийг тухайн бичлэгээс илрүүлсэн зүйлийн хувьд, ач холбогдолтой эсэхээс үл хамааран бүх холбогдох баримтууд, үзүүлэлтийг багтаана. Бичлэг тайлж уншсан тухай тайланд холбогдох бичиг баримтуудыг болон дуу, яриа, хөдөлгөөнт дүрслэлээр үзүүлсэн программын бичлэгийг CD-нд хуулан бичиж хавсаргана.

- Бодит хяналтын төхөөрөмжийн бичлэгээс нислэгийн үзүүлэлтүүдийг харуулсан баримт бичгийг 3 төрлөөр гарган авна. Үүнд: Хүснэгтэн мэдээлэл, график зургийн аргаар үзүүлэх, дуу авиа, хөдөлгөөнт дүрслэлээр үзүүлэх зэрэг орно.

- Агаарын хөлгийн нислэгийн өгөгдлийг шинжлэн шалгах хэсгийн үүрэг нь FDR-аас мэдээлэл өгөгдсөн нөхцөлд агаарын хөлгийн хөдөлгөөнийг тодорхойлох явдал юм. Энэ хэсэг нь бүхээгийн ярианы бичлэг, нислэгийн мэдээллийн бичлэг, радарын мэдээллийн бичлэг, агаарын нислэгийн үеийн яриа, фото зураг, видео бичлэгүүдийн мэдээллийг ашиглах боломжтой хэлбэрээр хангалттай мэдээлэл цуглуулж авч янз бүрийн үйл явдлуудыг олж тогтоохын тулд агаарын хөлгийн бодит хяналтын төхөөрөмжийн бичлэгийн тусламжтай хөдөлгөөнт дүрсийн мэдээлэл боловсруулна.

- Энгийн хөдөлгөөнт дүрсийг бүтээхдээ зориулалтын программ ашиглана. тэдгээрийн зарим хэсгийг видео дэлгэц дээр харуулж болно. Ийм төрлийн дэлгэц нь үйл ажиллагааны чиглэлийн шинжлэн шалгагчдад тустай. Энэ форматын зорилго нь тайланг эмх цэгцтэй бөгөөд нэгдсэн нэг загвар стандартын байдлаар бэлтгэх зорилготой.

- Агаарын хөлгийн цагийг маш өндөр нарийвчлалтай тохируулна. Ихэнх бодит хяналтын төхөөрөмжийн бичлэгийн хэрэгсэл нь мөн маш өндөр нарийвчлалтай GPS цагийн эх үүсвэрийг ашигладаг. Аналог системүүд нь тусгай суваг дээр бичигдсэн /зориулалт ба дугаартай/ цагийн дижитал сигналыг ашигладаг. Авиа компани юм уу хяналтын ажилтнууд нь цагийн

АГААРЫН ХӨЛГИЙН БОДИТ ХЯНАЛТЫН ТӨХӨӨРӨМЖҮҮД, НИСЛЭГИЙН  
ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН БИЧЛЭГИЙГ АВАХ, ХАМГААЛАХ, ХАДГАЛАХ ЖУРАМ

тохируулгыг өдөр бүр шалгаж байх ёстой. Үүнийг шинжлэн шалгах ажиллагааны хүрээнд гүйцэтгэх ёстой. Янз бүрийн эх үүсвэрүүдийг /замын, буултын, цамхгийн г.м/ ашигласан цагуудыг тааруулсан байх ёстой.

- Агаарын хөлгийн бодит хяналтын төхөөрөмжийн бичлэгийг тайлж уншсан тайланг гаргахдаа хавсралт 13-ын нэмэлт С ба Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 9756-р баримт бичгийн 4-р хэсэгт заасан тайлангийн форматыг баримтална. Энэ нь С хавсралтад байгаа ба тэнд мөн эцсийн тайлангийн хэсэг тус бүрд хамаарах материалын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх болно.

- Энэхүү ослын шинжилгээний тайлангийн монгол ба англи хувилбаруудын хооронд зөрүү илэрвэл монгол хувилбарыг нь баримтална. /Энэ өгүүлбэрийг, тайланг англи хэл рүү орчуулсан тохиолдолд нэмж оруулна./

**2.18. Агаарын хөлгийн нислэгийн бодит хяналтын бичлэгийн төхөөрөмжийн шинжилгээний лабораторийн үзлэг**

- Нислэгийн бичлэг тайлж унших ажиллагааг явуулахын өмнө бичлэг тайлагч нь бодит хяналтын төхөөрөмжийг шалган үзэж, тухайн лабораторийн нөхцөлд үйл ажиллагаа явуулж болох эсэх, дамжуулалтын кабель, программ хангамж нь тохирох эсэхийг нь тодорхойлж, энэхүү дүрмийн дагуу дүгнэлт гаргаж, шийдвэрлэх ёстой.

- Хэрвээ томоохон эвдрэл гарсан буюу бичлэгийг хуулж авах боломжгүй гэж үзэж байгаа болон бодит хяналтын төхөөрөмжийг задалж, нарийвчлан шинжлэн шалгах тоног төхөөрөмж байхгүй бол тухайн бичлэгийн төхөөрөмжийг тохирох байгууллага руу шалгуулахаар явуулна. Шинжилгээний үйлчилгээг зохион байгуулахын өмнө дараах зүйлүүдийг анхаарна.

- гадаад улсын ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй байгууллагын шинжлэн шалгах лабораторийн тусламжтайгаар үйл ажиллагаа явуулах.

- Эдгээр үйлчилгээг сонгох үедээ гарч болох эрх ашгийн зөрчлийг болгоомжтой тооцох шаардлагатай.

- Шинжилгээний зорилгоор нислэгийн бичлэгийн төхөөрөмжийн задаргаа хийх тохиолдолд, ажиллагаа эхлэхээс өмнө түүний бүх талуудыг нарийн нягтлан зургийг авч, задаргаа хийж буй үйл явцыг видео бичлэг хийж авах ба задаргаа хийсэн зүйлүүдийн бүртгэл хийж баталгаажуулах ёстой.

- Нислэгийн бодит хяналтын төхөөрөмжийн нарийн зөв түүхийг өгөх ба үүнд дараах мэдээлэл орно.

- Үйлдвэрлэсэн газар
- Сериал дугаар
- Part Number
- Суурилуулсан огноо
- Ашиглалтад авсан огноо
- засвар үйлчилгээ хийж баталгаажуулсан газар
- Засвар үйлчилгээ хийж баталгаажуулсан огноо
- Их засвар ба үзлэгээс хойш өнгөрсөн хугацаа
- Бусад шаардлагатай мэдээлэл

- Бичлэгийн бодит хяналтын төхөөрөмжийн бусад холбогдох хэсгүүд ба эд ангиуд, цахилгааны холболтын суурь, кабель утаснууд дагалдуулж болно.

- Бодит хяналтын төхөөрөмжийг хүлээн авсан бичлэг тайлагч нь өмчлөгчид нь буцаан явуулах хүртэл тухайн төхөөрөмжийн хадгалалт, хамгаалалтыг хариуцах мэдээллийн нууцыг чанд хадгална.

АГААРЫН ХӨЛГИЙН БОДИТ ХЯНАЛТЫН ТӨХӨӨРӨМЖҮҮД, НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН БИЧЛЭГИЙГ АВАХ, ХАМГААЛАХ, ХАДГАЛАХ ЖУРАМ

- Бодит хяналтын төхөөрөмж нь бичлэг тайлах ажиллагаанд цашид хэрэггүй гэж үзсэн үед тухайн төхөөрөмжийн өмчлөгч буюу үйл ажиллагаа явуулагчийн хүсэлтээр буцааж шаардлагатай арга хэмжээг авна.
- Бодит хяналтын төхөөрөмжийг буцаасныг бичгээр баримтжуулж, өмчлөгч буюу үйл ажиллагаа явуулагч хүлээн авсан бичгэн дээр гарын үсэг зуруулна. /Хавсралт 1/.

### **Гурав. Нислэгийн хөдөлгөөний удирдлага (НХУ)-ын ярианы бичлэгийг шинжлэн шалгах үйл ажиллагаа**

3.1. НХУ-ын ярианы бичлэгийг шинжлэн шалгах үйл ажиллагаанд ашиглахаар шинжлэн шалгах үйл ажиллагаа явуулж буй эрх бүхий байгууллагын шинжлэн шалгагчид хүсэлт гаргана.

3.2. Нислэгийн хөдөлгөөний удирдлага, агаарын хөлгийн нисэгч хоорондын яриа бичлэгийг Хавсралт 2-д үзүүлсэн маягтын дагуу хүснэгт бөглөж гарын үсэг зурж хүлээлцэж авна.

3.3. Нислэгийн хөдөлгөөний удирдлагын ярианы бичлэгийг эх хувиас нь хуулбарлан авах ба зөөврийн дискэнд (CD, хуурцаг, flash, ZIP, уян диск) хуулан файл хэлбэрээр авна. Бичлэгийн төрөл нь аудио бичлэг байна.

3.4. Албаны шинжлэн шалгагчид нь анхны НХУ-ын бичлэгийг сонсоно. /хуурцаг, диск юмуу дижитал бичлэг байж болно/

3.5. Байгууллагууд нь ерөнхийдөө хяналтын байрлалд байгаа чихэвчтэй холбогдсон утаснаас бичлэг хийдэг. Радио системээс юу дамжуулж хүлээн авсан гэдэг талаар ямар нэг асуулт гарч ирэх юм бол бусад бичлэгийн цэгүүд байсан эсэх ба тэдгээр нь осол зөрчлийн үед бичлэг хийж байсан эсэхийг илрүүлэх зорилгоор нисэхийн байгууллагын техникчидтэй зөвлөлдөх шаардлагатай байж болно. Хэдийгээр энэ нь ховор зүйл боловч хоёр бичлэгийг харьцуулахад зөрүү гарч болно.

3.6. Бичлэгийн хоорондох тасалдал байхгүй гэдгийг баталгаажуулахын тулд хугацаа хэмжигчийг ажиглана. Таны ажлын хуулбар зөв гэдгийг баталгаажуулахын тулд бичмэлийн эх хувийг бичлэгтэй тулгаж уншина. Хугацаа нь 1 юм уу 2 секундээс илүү хугацаагаар зөрж байвал бичлэгийг хариуцсан байгууллагын ажилтанд энэ талаар мэдэгдэнэ. Цаг хугацааг баталгаажуулсан бичмэл дээр засварлаагүй бол та өөрийн тайланд энэ талаар тайлбар бичнэ. Өмнө нь өгсөн кассетны ажлын хуулбарыг өөртөө авч явах нь зүйтэй боловч та НХУ-ын анхны хуурцгийг сонсох ёстой. Баталгаажсан давхар бичлэг нь цаг хугацааг нэг суваг дээр, дуу авиаг өөр суваг дээр бичсэн стерео бичлэг байдаг бол ажлын хуулбарууд нь голдуу ганцхан дуу хоолойны сувгийг ашигладаг.

### **Нислэгийн хөдөлгөөний удирдлагын шаардлагатай бичиг баримт**

3.7. АЛБА нь шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагатай нислэгийн хөдөлгөөний удирдлагын бичиг баримтыг Нислэгийн хөдөлгөөний Албанаас гаргуулж авна.

3.8. Осол зөрчилд холбогдсон агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөний удирдлагаар хангагдсан байдал, нотлох баримтыг тогтоох зорилгоор Нислэгийн хөдөлгөөний удирдлагын бичиг баримтыг гаргуулж авна. НХУ-ын бичиг баримтыг Хавсралт 2-д үзүүлсэн маягтын дагуу баримт бүрдүүлж баталгаажуулж авна.

3.9. Нислэгийн хөдөлгөөний удирдагч, агаарын хөлгийн нисгэгч хоорондын яриа бичлэгийг бичиж, хадгалах үйл ажиллагааг "Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны дүрэм"-ийн дагуу хийж гүйцэтгэнэ.

АГААРЫН ХӨЛГИЙН БОДИТ ХЯНАЛТЫН ТӨХӨӨРӨМЖҮҮД, НИСЛЭГИЙН  
ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН БИЧЛЭГИЙГ АВАХ, ХАМГААЛАХ, ХАДГАЛАХ ЖУРАМ

3.10. Баталгаажсан бичмэл. Хэсэгчилсэн бичмэл нь тухайн агаарын хөлөг нь осол болохоос өмнө ашиглаж байсан давтамжийг хамруулахад л хангалттай байдаг. Агаарын хөлөг ослын үед ашиглаж байсан давтамжийг олохын тулд бүрэн бичмэлийг авах хүсэлт гаргана. Хэсэгчилсэн бичмэл нь зөвхөн НХУ ба осолд орсон агаарын хөлөг мөн холбогдох утсан дээр байсан хүмүүсийн хоорондох яриаг хамардаг бол бүрэн бичмэл нь холбогдох бичлэгүүдийн бүх яриаг хамардаг.

3.11. Нислэгийн удирдагчийн хянах юм уу холбоо барих шууд хариуцлага хүлээж байсан эсвэл нислэгтэй холбоотой мэдээллийг бэлтгэх юм уу мэдээлэлтэй харьцаж байсан, нислэгийн үйл ажиллагааны аливаа хэсгийг гэрчилсэн, ослын үр дүнд авсан шуурхай арга хэмжээнд оролцсон, осол болсноос 24 цагийн дотор нислэгийн багт цаг агаарын мэдээлэл өгсөн мэдүүлгийн хүмүүст хамааралтай гаргасан мэдүүлгийн хуулбарыг өгнө. Мэдүүлгийг ослын үед жижүүрлэж байгаа ахлагчаас авна.

- Ослын үед нислэгийн удирдагчийн хэрэглэж байсан бүх тэмдэглэл, нислэгийн үйл явцын тууз, тэмдэглэлийн дэвтэр, маягт, санамж бичгийн хуулбарууд, мөн байгууллагын тушаал ба Албан тушаалын үүргийн холбогдох бүлгүүдийн хуулбар.

- Ажлын байран дээр сургалт явагдсан бол сургалтын талаарх байгууллагын тушаал ба сургагч нь шаардлага хангасныг харуулсан гэрчилгээний хуулбар, мөн осол зөрчилд хамааралтай үеийн сургалтын үнэлгээний хуулбар

- Байгууллагын схем зураг

- Нислэгийн хөдөлгөөний байгууллага ба бусад байгууллага мөн тээвэрлэгчдийн хоорондох холбогдох баримт бичгүүд

- Осол зөрчлийн үед жижүүрлэж байсан эрх бүхий ажилтнууд ба ээлжийн хуулбар

- Осол, зөрчил гарсан өдрийн нисэх буудлын үйл ажиллагааны ба тоног төхөөрөмжийн байдалд хамаарах бүх NOTAM-ын хуулбар

- Осол, зөрчил гарсан өдөр ба үед хамаарах бүх SIGMET, AIRMET, CWA, цаг уурын нөлөөний мэдээ, нисэх буудлын цаг агаарын урьдчилсан мэдээ, тухайн үеийн цаг агаарын ажиглалтын хуулбар

- Байгууламжийн тоног төхөөрөмжийн байдлын бичиг баримт

- Байгууламжийн засвар үйлчилгээний бүртгэлийн дэвтрүүд

- Шаардлагатай бол өмнөх нислэгийн NAVAID-ын шалгалт

- Ослын дараах нислэгийн шалгалтын тайлан

- Багаж хэрэгсэлтэй харьцах журмын хуулбар, тэр дундаа багаж хэрэгсэлтэй харьцах журам багтсан бол агаарын тээврийн байгууллагад хадгалагдаж байгаа бүдүүвч зураг

3.12. Шинжлэн шалгах ажиллагааг явуулж буй эрх бүхий байгууллагын шинжлэн шалгагч нь холбогдох Албаны хүмүүстэй ярилцлага явуулахдаа АЛБА-ны "Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны дүрэм"-ийн дагуу хийж гүйцэтгэнэ.

3.13. НХУ-ын хэсгийн тайланд гүйцэтгэсэн ажлуудын дүгнэлт холбогдох дуу авиан бичмэлийн хуулбарууд, агаарын хөлгийн хөдөлгөөний радарын зураглал, хөдөлгөөний удирдагчдын мэдүүлэг, байгууллагын холбогдох бүртгэл тэмдэглэлийн хуулбаруудыг багтаасан байх ёстой.

### Цагийн эх үүсвэр

3.14. Радарын цагийг маш өндөр нарийвчлалтай GPS цагаар тохируулна. Ихэнх дижитал дуу авианы бичлэгийн хэрэгсэл нь мөн маш өндөр

АГААРЫН ХӨЛГИЙН БОДИТ ХЯНАЛТЫН ТӨХӨӨРӨМЖҮҮД, НИСЛЭГИЙН  
ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН БИЧЛЭГИЙГ АВАХ, ХАМГААЛАХ, ХАДГАЛАХ ЖУРАМ

нарийвчлалтай GPS цагийн эх үүсвэрийг ашигладаг. Аналоги системүүд нь тусгай суваг дээр бичигдсэн /зориулалт ба дугаартай/ цагийн дижитал сигналыг ашигладаг.

3.15. Техник үйлчилгээ хариуцсан байгууллага юм уу нислэгийн хөдөлгөөний ажилтнууд нь цагийн тохируулгыг өдөрт дор хаяж 2 удаа шалгаж байх ёстой. Үүнийг шинжлэн шалгах ажиллагааны хүрээнд гүйцэтгэх ёстой. Янз бүрийн эх үүсвэрүүдийг /замын, буултын, цамхгийн г.м/ ашигласан цагуудыг тааруулсан байх ёстой.

3.16. Нислэгийн хөдөлгөөний ярианы бичлэг

а) Ослыг шинжлэн шалгах ажиллагаанд Нислэгийн хөдөлгөөний Албаны ярианы бичлэгийг өргөнөөр ашиглах ба тухайн Нислэгийн хөдөлгөөний Албаны журам, мөн хуурцан дээр бичигдсэн дуу хоолойны талаар мэдэх ажилтнаас тусламж авч болно. Ихэнх Нислэгийн хөдөлгөөний албаны бичлэг хийх төхөөрөмж нь нь олон давтамжаар, өөр өөр суваг дээр зэрэг бичлэг хийдэг. Компанийн хөдөлгөөний зохицуулалт, нисэх буудлын үйлчилгээний давтамжууд, тухайн орчны Нислэгийн хөдөлгөөний алба зэрэг байгууллагуудын бичлэг олдож болно. Зарим арилжааны радио станцууд нь үйл явдлын мэдээлэл хайж янз бүрийн үүний дотор нисэх болон осол, гамшгийн радио долгионы давтамжуудыг байнга хянаж байдаг тул шинжлэн шалгах ажлын энэ тал дээр туслалцаа үзүүлж байгаа аливаа хүмүүст эдгээр бичлэгийн давуу талыг тайлбарлах ёстой.

б) Дуу ярианы бичлэгийг ажилтнуудын сэтгэлийн дарамттай байдлын шинж тэмдгийг шинжлэхэд голдуу түгээмэл хэрэглэдэг ба давтамжийн спектрийн шинжилгээ нь хөдөлгүүр, араа, роторын эргэлтийн хурд, араа салгалт эсвэл тэсрэлтийн шинж тэмдгийг илрүүлж чаддаг. Хуурцаг дээр удаан хугацааны турш бичлэг хийгдээгүй байсан ч ослын үед хамаарах ослын бүх бичлэгийг эхэлж сонсох ёстой. Аудио хуурцаг нь амархан эвдэрдэг бөгөөд соронзонтой учраас гэмтэх, арчигдахад амархан байдаг. Тиймээс зөвхөн сургалтад хамрагдсан хүмүүс харьцах ёстой. Соронзон хуурцгийг тээвэрлэх үед саван дээр нь /халуун ба соронзонгийн эх үүсвэрээс хол байлга/ гэсэн бичилт хийнэ.

**Дөрөв. Бодит хяналтын төхөөрөмжийн бичлэг,  
нислэгийн хөдөлгөөний удирдлагын ярианы бичлэг,  
бичиг баримтыг хадгалах, хамгаалах**

4.1. Үйл ажиллагааны дүрмийн дагуу осол, ноцтой зөрчил болсон тохиолдолд, тухайн нислэгтэй холбоотой байж болох бүх бичлэгүүд, бодит хяналтын төхөөрөмжүүдийн бичлэг, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний холбооны ярианы бичлэг ба бичиг баримтуудыг цаашид хэрхэх талаар зааварчилгаа авах хүртэл хамгаалж, хадгална.

4.2. Осол, ноцтой зөрчлийн үеийн агаарын хөлгийн бодит хяналтын төхөөрөмжүүдийн нислэгийн өгөгдлийн бичлэг /FDR/, бүхээгийн ярианы бичлэг /CVR/, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний бичлэг /HXU/ болон холбогдох бичиг баримтуудыг АЛБА-ны агуулах, архивд бичгээр болон файлаар хадгална.

4.3. АЛБА нь шаардлагатай хугацаанд агаарын хөлгийн бодит хяналтын төхөөрөмжүүд, түүний бичлэгийг хамгаалж, хараа хяналтдаа байлгах тэр дундаа тэдгээрийг нэмж гэмтээх, зөвшөөрөлгүй хүмүүст өгөх, түүнд нэвтрэх, хулгай хийх, байдлыг муутгахаас хамгаална.

АГААРЫН ХӨЛГИЙН БОДИТ ХЯНАЛТЫН ТӨХӨӨРӨМЖҮҮД, НИСЛЭГИЙН  
ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН БИЧЛЭГИЙГ АВАХ, ХАМГААЛАХ, ХАДГАЛАХ ЖУРАМ

4.4. Шаардлагатай бол бичлэг, холбогдох бичиг баримтуудын талаар шинжлэн шалгах ажиллагааны өмнө, дунд, дараа тэмдэглэл хөтөлж, нууцлалын бүртгэл хийнэ.

4.5. Эд мөрийн баримт алдагдахаас сэргийлж, баримтжуулах зорилгоор бодит хяналтын төхөөрөмжүүдийн фото зургийг авах, тэдгээрийн үйлдвэрийн дугаар, маягийг тэмдэглэж авах, бүртгэл хөтөлнө.

4.6. Агаарын хөлгийн ашиглагч нь сүүлийн 12 сарын турш хийсэн нислэгийн бичлэгийг хадгалах шаардлагатай. Энэ нь осол, зөрчил гарсан тохиолдолд агаарын хөлгийн шинжлэн шалгах ажиллагаа явуулж буй шинжлэн шалгагчид өмнөх нислэгийн өгөгдлийг авч дүн шинжилгээ хийж ашиглах боломж бүрдэнэ.

4.7. Бодит хяналтын төхөөрөмж тус бүр дээр түүний нэр, партын дугаар, серийн дугаар, ашиглагч байгууллагын нэр, хаягийг бичсэн шошго хадах ёстой. Бичлэг тайлагч нь агаарын хөлгийн өгөгдлийг авах ёстой бодит хяналтын төхөөрөмжийн жагсаалт, тодорхойлолт, фото зургийг хадгалах ёстой. Түүнийг буцааж тээвэрлэх хүртэл хамгаалалттай байранд хадгална.

4.8. Бодит хяналтын төхөөрөмжүүдийг тээвэрлэлтийн үед аль болох бага гэмтэхээр баглаж, гаднын нөлөө, соронзон орон, статистикийн нөлөөнөөс хамгаалсан тохирох баглаа боодлын материалаар хамгаалагдсан тусгай таних тэмдэгтэй хайрцагт хийх ёстой.

4.9. Бичлэг тайлагч нь бүх хайрцаг, савуудыг зохих ёсны дагуу хаяглаж, тус бүрд нь жагсаалт гаргана.

4.10. Нислэгийн өгөгдлийн бичлэгийг тайлж уншсан бичиг баримт, тэмдэглэл, холбогдох файлыг тухайн байгууллагын бичлэг тайлах ажиллагааг хариуцсан ажилтан хадгалах ёстой ба үр дүнг нь бүртгэн, тэмдэглэж, архивлана.

4.11. Нууцлалтай бичлэг, баримт бичгийг нууцын тэмдэглэгээ хийн маягтын /Хавсралт 3/ дагуу бүртгэж, хадгална.

4.12. Ярианы болон дүрс бичлэгийн аюулгүй байдлыг хамгаалж, тусгаарлагдсан, хамгаалалттай өрөө тасалгаанд хадгална.

**Агаарын хөлгийн осол, зөрчилтэй холбоотой бичлэгүүд, бичиг баримтыг буцаах, устгах**

4.13. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа дуусаж, эцсийн тайлан гарсан бол холбогдох бичлэг, бичиг баримтуудыг эзэмшигч байгууллагад буцаан олгоно.

4.14. Хамгаалагдсан агаарын хөлгийн бүхээгийн ярианы болон дүрс бичлэгийн төхөөрөмжийг буцаах шаардлагатай үед бичлэгийг кодлож буюу устгаж өгнө.

4.15. Бодит хяналтын төхөөрөмжүүд, бичлэг бүхий мэдээлэл хадгалах төхөөрөмж, холбогдох бичиг баримтыг бичгээр баримтжуулж, өмчлөгч буюу үйл ажиллагаа явуулагчид буцааж олгохдоо хавсралт 2-д үзүүлсэн маягтын дагуу баримт бүрдүүлж, гарын үсэг зурж буцаан олгоно.

4.16. Буцаах шаардлагагүй бичлэг болон бичиг баримтыг агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны агуулахад хадгалах бөгөөд эцсийн тайлан гарснаас хойш 5 жилийн хугацаанд хадгална. Түүнээс хойш шинжлэн шалгах албаны даргын шийдвэрээр устгалд оруулж болно.

**БОДИТ ХЯНАЛТЫН ТӨХӨӨРӨМЖ, ХОЛБОГДОХ БИЧИГ БАРИМТЫГ  
ХҮЛЭЭЛЦЭХ ХҮСНЭГТ**

Эзэмшигч	А/х-ийн үйлдвэрлэгч, загвар	А/х-ийн бүртгэлийн дугаар	Аялалын дугаар	Ангилал
Байрлал, Нислэгийн чиглэл	Огноо, цаг	Хүлээлгэн өгсөн:		
		Бичлэгийн төхөөрөмж /Загвар, PN, SN/	Бичиг баримт	
Нисэх багийн тэмдэглэл		Код /нислэгийн төрөл, үе шат, нислэгт нөлөөлсөн хүчин зүйл/	Тэмдэглэл /үндэслэл, осол зөрчлийн мэдээлэл, хамтын ажиллагааны гэрээ, заавар/	

-\*Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах Албаны дүрмийн дагуу би дээрх бодит хяналтын төхөөрөмж, холбогдох бичиг баримтыг тус Албанд хүлээлгэж өгснийг баталж байна.

Эзэмшигч болон эзэмшигчийг төлөөлж:

Овог нэр \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /  
(гарын үсэг)

Хаяг \_\_\_\_\_

Утас: \_\_\_\_\_

**Хүлээн авсан:**

АЛБА-ыг төлөөлж: Овог нэр \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /  
(гарын үсэг)

Хүлээн авсан огноо: \_\_\_\_\_

-\* Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах Албаны дүрмийн дагуу би дээрх бодит хяналтын төхөөрөмж, холбогдох бичиг баримтыг (\_\_\_\_\_) шинжлэн шалгах ажиллагаа дууссан тул эзэмшигч болон ашиглагчид буцааж хүлээлгэж өгснийг баталж байна.

АЛБА-ыг төлөөлж: Овог нэр \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /  
(гарын үсэг)

**Хүлээн авсан:**

Эзэмшигч болон эзэмшигчийг төлөөлж:

Овог нэр \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /  
(гарын үсэг)

Хаяг \_\_\_\_\_

Утас: \_\_\_\_\_

Буцааж хүлээлгэн өгсөн огноо: \_\_\_\_\_

**ЯРИАНЫ БИЧЛЭГ, ХОЛБОГДОХ БИЧИГ БАРИМТЫГ  
ХҮЛЭЭЛЦЭХ МАЯГТ**

Эзэмшигч	Агаарын хөлгийн маяг	Аялалын дугаар	Бүртгэлийн дугаар	Зөрчлийн ангилал
<b>Байрлал</b>	<b>Огноо</b>	<b>Хүлээлгэн өгсөн</b>		
		Ярианы бичлэг	Бичиг баримт	
<b>Өгсөн баримтын нэр</b>		<b>Код</b>	<b>Тэмдэглэл</b>	

Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах Албаны дүрмийн дагуу би дээрх ярианы бичлэг, холбогдох бичиг баримтыг тус Албанд хүлээлгэж өгснийг баталж байна.

Эзэмшигч болон эзэмшигчийг төлөөлж:

Овог нэр \_\_\_\_\_ (гарын үсэг) \_\_\_\_\_

Хаяг \_\_\_\_\_

Утас: \_\_\_\_\_

Хүлээн авсан АЛБА--ны хүний нэр: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /  
(гарын үсэг)

Хүлээн авсан огноо: \_\_\_\_\_

Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах Албаны дүрмийн дагуу би доорх ярианы бичлэг, холбогдох бичиг баримтыг ( \_\_\_\_\_ )

\_\_\_\_\_ )  
эзэмшигч болон ашиглагчид шинжлэн шалгах ажиллагаа дууссан тул буцааж хүлээлгэж өгснийг баталж байна.

АЛБА-ыг төлөөлж: Нэр \_\_\_\_\_  
(гарын үсэг)

Эзэмшигч болон эзэмшигчийг төлөөлж:

Овог нэр \_\_\_\_\_ (гарын үсэг) \_\_\_\_\_

Хаяг \_\_\_\_\_

Утас: \_\_\_\_\_

Буцааж өгсөн огноо: \_\_\_\_\_

НИСЛЭГИЙН БИЧЛЭГИЙН ТӨХӨӨРӨМЖИЙН БИЧЛЭГ ТАЙЛАХ  
АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ, НУУЦЛАЛЫН БҮРТГЭЛ

№	Бодит хяналтын төхөөрөмж, бичлэг, холбогдох бичиг баримт	Эзэмшигчийн нэр, хаяг	Огноо, хугацаа	Нууцлалын зэрэг	Хүлээлгэн өгсөн хүний гарын үсэг	Тайлбар
1						
2						
3						
4						
5						

АГААРЫН ХӨЛГИЙН БОДИТ ХЯНАЛТЫН ТӨХӨӨРӨМЖҮҮД, НИСЛЭГИЙН  
ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН БИЧЛЭГИЙГ АВАХ, ХАМГААЛАХ, ХАДГАЛАХ ЖУРАМ

Хавсралт 4

**НИСЛЭГИЙН БИЧЛЭГИЙГ ТАЙЛЖ УНШИХ, ШИНЖЛЭХ ХЯНАЛТЫН МАЯГТ**

**I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Осол, зөрчлийн дугаар		Байгууллага / лаборатори	
Огноо		Хариуцсан шинжлэн шалгагч	
Агаарын хөлгийн бүртгэл			

**II. ХЯНАЛТЫН АСУУЛТ**

№	Шалгах асуулт	Тийм	Үгүй	Тайлбар
Д.1.1	Осол, ноцтой зөрчил гарсны дараа нислэгийн бичлэгийг тайлж унших, шинжлэх ажиллагааг аль болох богино хугацаанд зохион байгуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Д.1.2.а	Ослын газрын түр зуурын шинжтэй нотлох баримтыг үнэлэх хэрэгцээг тодорхойлсон эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Д.1.2.б	Шинжлэн шалгах ажиллагааны чиглэлийг зөв тодорхойлох зорилгоор нислэгийн бичлэгийн мэдээллийг ашигласан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Д.1.2.в	Шаардлагатай тохиолдолд яаралтай аюулгүй байдлын зөвлөмж боловсруулах үндэслэл бүрдүүлсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Д.1.3	Өөрийн улсын техник, лабораторийн боломжгүй тохиолдолд зохих чадавх бүхий бусад улсаас туслалцаа авсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Д.1.4	Нислэгийн бичлэгийг тохиромжтой байгууллага, лабораторид тайлж уншуулах ажлыг цаг алдалгүй зохион байгуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Д.2.1	Тухайн шинжлэн шалгах ажиллагаанд хамгийн үр дүнтэй дэмжлэг үзүүлэх байгууллага, улсыг сонгосон эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Д.2.2	Энгийн зориулалтын бичлэг тайлах төхөөрөмж, програм хангамжийг хангалттай гэж үзсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Д.2.3	Нислэгийн бичлэг гэмтсэн тохиолдолд сэргээх, тайлж унших, шинжлэх тусгай арга, технологи ашигласан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Д.2.4.а	Ноцтой гэмтэл авсан бичлэгийн төхөөрөмжийг задлах, сэргээх, тайлж унших боломжийг шалгасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Д.2.4.б	Анхны бичлэг, санах ойн модулийг үйлдвэрлэгчийн хуулбарлах төхөөрөмжгүйгээр тайлж унших боломжтой эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Д.2.4.в	2-тын системийн түүхий өгөгдөлд шинжилгээ хийх боломжтой эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Д.2.4.г	Дуу бичлэгийг тоон хэлбэрээр шүүн сайжруулах програм хангамжтай эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Д.2.4.д	Өгөгдлийг графикаар шинжилж, баталгаажуулж, нэмэлт үзүүлэлт тооцоолох чадавхтай эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Д.3.1	Үйлдвэрлэгч улс, эсхүл зохион бүтээгч улсын мэргэжлийн оролцооны хэрэгцээг тогтоосон эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Д.3.2	Тайлж унших ажиллагаа өөр улсад хийгдэж байгаа бол үйлдвэрлэгч улс, зохион бүтээгч улсын төлөөлөгчийг оролцуулах арга хэмжээ авсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Д.4.1	Үйл ажиллагаа эрхлэгч улсын зохицуулалтын мэдээлэл, үйл ажиллагааны онцлог нөхцөлийг харгалзан үзсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Д.4.2	Үйл ажиллагаа эрхлэгч улсын төлөөлөгчийг оролцуулах арга хэмжээ авсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Д.5.1	Нислэгийн өгөгдлийн бичигч болон бүхээгийн дуу бичигчийг нэг байгууллагаар тайлж уншуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Д.5.2	Тайлж уншихаас өмнө төхөөрөмжийг нээх, цахилгаанд залгах, анхны бичлэгийг хуулбарлахыг хориглосон шаардлагыг мөрдсөн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Д.5.3	Бусад улсын хүсэлтээр тайлж уншсан байгууллагад эцсийн тайлангийн төсөлд санал өгөх боломж олгосон эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Д.5.4	Үйлдвэрлэгч болон Үйл ажиллагаа эрхлэгчийн техникийн дэмжлэгийг шаардлагатай тохиолдолд авсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Д.5.5	Анхны бичлэг, эсхүл хуулбарыг шинжлэн шалгах ажиллагаа дуусах хүртэл хадгалуулах хэрэгцээг шийдвэрлэсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Д.5.6	Бичлэг хадгалж байгаа байгууллага нь хангалттай аюулгүй байдлын журам, хамгаалалтын нөхцөлтэй эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	

**III. БАТАЛГААЖУУЛАЛТ**

Бэлтгэсэн ажилтан		Огноо	
Хянасан ажилтан		Гарын үсэг	

Нэмэлт тэмдэглэл: \_\_\_\_\_